



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/180

Булган сум

Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, 16 дугаар зүйлийн 16.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орхон сумын "Орхон" нэртэй 72.23 гектар талбайд XV-63000027 дугаартай түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч "Хөх хайрга" ХХК-ийн тусгай зөвшөөрлийн хугацааг 2022 оны 03 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн 2 жилийн хугацаатайгаар сунгасугай.

2. Холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулахыг тусгай зөвшөөрөл эзэмшигч "Хөх хайрга" ХХК (Д.Оюун-Эрдэнэ)-д зөвлөсүгэй.

3. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд холбогдох хуулийн дагуу хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Давааням), Байгаль орчин, аялал жуулчлалын газар (А.Гантөмөр), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн), Орхон сумын Засаг дарга (Н.Амартүвшин) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

